

**“МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ”-ИЙН
АРГА ХЭМЖЭЭНИЙ 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ**

2024 оны 11 дүгээр сарын 25

Улаанбаатар хот

Д/Д	Арга хэмжээ	Төсөв (сая төг)		Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин		Хэрэгжилт	Хүрсэн түвшин, гүйцэтгэлийн хувь
		Төсөвлөсөн	Гүйцэтгэл /зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)		Он	Түвшин	Он	Түвшин		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	2.7.3.гадаадын иргэн, харьяалал-гүй хүн, цагаачдын тооны зохист түвшнийг хадгалах, хяналт тавих тогтолцоог бэхжүүлнэ.	-	-	Гадаадын иргэн, харьяалал-гүй хүн, цагаачдын тооны харьцаа	2023	2023 онд Монгол Улсад цагаачлан оршин суугч нийт 1836 гадаадын иргэн байсан нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд заасан хэмжээнээс хэтрээгүй.	2024	Хуулийн хүрээнд зохист түвшний хязгаарыг алдагдуулахгүй байх	Гадаадын иргэн, харьяатын газраас “Монгол Улсад 2021-2024 онд цагаачлуулж болох гадаадын иргэдийн тоо, бүтэц, байршлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, танилцуулгыг 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 01/1730 дугаар, 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 01/2075 дугаар албан бичгээр тус тус Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлсэн. Монгол Улсад 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар 1779 гадаадын иргэн, үүнээс хамгийн их буюу Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 1220 иргэн Монгол Улсад цагаачлан оршин суухаар бүртгэлтэй байгаа нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсэгт заасан хэмжээнээс мөн хэтрээгүй байна.	100

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
2	7.2.4. гадаадын иргэдийг улсын хилээр нэвтрэх үед биеийн давхцахгүй өгөгдлийг авч, нэгдсэн санд бүртгэх тогтолцоог бүрдүүлнэ.	-	-	Гадаадын иргэн, харьяалалгүй хүний биеийн давхцахгүй өгөгдөл бүхий бүртгэлийн системийн хөгжүүлэлт	2023	Программ хангамж, тоног, төхөөрөмжийн тоо-1	2024	Үйл ажиллагаа хэвийн явагддаг болсон байна.	“Гадаадын иргэний виз, бүртгэл мэдээллийн нэгдсэн сан (isf.mn)” системийг нэвтрүүлэх арга хэмжээг 2022 онд Хууль зүй, дотоод хэргийн сайдын улсын төсвийн хөрөнгө оруулалтын “Тоног төхөөрөмж” багцаас 470.0 сая төгрөгийн санхүүжилтээр ашиглалтад оруулсан. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, И-Монгол академитай хамтран танилт нэвтрэлтийн ДАН системд гадаадын иргэний бүртгэл (F-Register) ашиглан нэвтрэх үйлчилгээг уг системтэй 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрөөс холбон үйлчилгээ үзүүлж эхэлсэн. “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” системд нийт 636 удаагийн засвар, шинэчлэлийг хийж, хөгжүүлэлтийг сайжруулан тайлант хугацаанд визийн зөвшөөрөл, виз олголт, оршин суух зөвшөөрөл, оршин суух зөвшөөрлийн хугацаа сунгалт, оршин суух зөвшөөрлийн хасалт, гадаадын иргэний хаягийн бүртгэл, гадаадын иргэний 48 цагийн бүртгэлтэй холбоотой 47174 хүсэлтийг хүлээн авч, тус тус хянан шийдвэрлэлээ. Эдийн засаг, хөгжлийн яам, Азийн хөгжлийн банктэй хамтран хэрэгжүүлж буй "МОН3936: Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл"-ийн бүрэлдэхүүн хэсэг ЗҮ-03: “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем хөгжүүлэлт” төслийн хүрээнд байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээг цахим хэлбэрт бүрэн шилжүүлсэн. Системийн санхүүжилтийг 2022 онд Хууль зүй, дотоод хэргийн яамнаас шийдвэрлэсэн бөгөөд 2024 онд хөгжүүлэлтэд байгууллагаас төсөв зарцуулаагүй болно.	100
3	7.4.7. Хууль сахиулах байгууллагууд иргэдийн	-	-	-	2023	Цахим нэгдсэн сүлжээнд	2025	-	Хууль зүй, дотоод хэргийн салбарын архив, албан хэрэг хөтлөлтийн “edoc.mojna.gov.mn” программыг нэвтрүүлсэнтэй холбогдуулан төв, орон нутаг дахь нэгжийн нийт 258 албан	100

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	
	өргөдөл, гомдлыг шуурхай хянан шийдвэрлэх, түүнд хяналт тавих цахим нэгдсэн сүлжээнд бүрэн холбогдож, иргэдэд үйлчлэх таатай орчныг бүрдүүлнэ.					холбогд- сон байдал				хаагчийг системд бүртгэн уг системийн “Өргөдөл” цэсийг байгууллагын үйл ажиллагаанд бүрэн ашиглаж, шийдвэрлэлтийг хянаж байна.	
Үнэлгээ: 100 хувь											

--oo0oo--